

ХОВД АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018.10.01

Ховд

Тус Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэн, Монгол Улсын Их хурлаас батлан гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны болон тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрүүд, албан даалгавар, тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын өгсөн үүрэг, Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний стандарт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн актуудыг алба хаагчдаар судлуулах, тайлбарлан таниулах, бие бүрэлдэхүүнийг шинэ мэдээ мэдээлэлээр ханган, тэдний мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн мэргэжлийн удирдлагаар ханган ажиллав.

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

А. Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэг, зөрчлийг илрүүлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн туслалцаа дэмжлэгийг авах, тэднийг урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, иргэдийн санал санаачлагыг тусган хэрэгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, төрийн болон төрийн бус 81 байгууллага, аж ахуйн нэгжийг алба хаагчдад хариуцуулан хамтран ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газраас 2018 онд дэвшүүлсэн зорилт, Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний заалт, 2018 оны эхний хагас жилд хэрэгжүүлсэн ажлын ололттой ба дутагдалтай талд дүгнэлт хийж, төлөвлөгөөнд тусган алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг дээшлүүлэхэд анхааран ажилласан.

Нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдлын талаарх мэдээллийг аймгийн Засаг дарга, Хууль эрх зүйн хэлтэс, сумдын ИТХ-ын дарга нарт сар бүр хүргүүлж, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөрөнгө санхүүгийн дэмжлэг авч ажилласан.

Тухайлбал: Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр баруун бүсийн “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын төлөө хамтдаа шийдье” зөвлөгөөнд 5.000.000, “Хүүхэд хамгааллын хамтарсан багийн эргэн дүгнэлт” сургалт, зөвлөгөөнд 1.000.000, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” баруун бүсийн сургалт, зөвлөгөөнд 1.500.000, нийт 8.000.000 төгрөгийг санхүүжүүлсэн.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүл бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах урьдчилан сэргийлэх чиглэлээр түр хамгаалах байрны нөхцөл байдлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцуулан, Хөшөөт хөгжил сангаас 1 сая 480 мянган төгрөг шийдвэрлүүлэн түр хамгаалах байрны 4 цонхонд 880 мянган төгрөгийг

решотик буюу хамгаалалтыг хийж, 600 мянган төгрөгний үнэтэй хяналтын 3 камер суурилуулсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, ажил, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, иргэдийн санал хүсэлтийг сонсох, хүлээн авах, зорилгоор 2018 оны 3 дугаар улиралд Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Өмгөөлөгчдийн холбоо, Ховд их сургууль, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран 4 удаа өдөрлөг зохион байгуулж, иргэдийн дунд хууль эрхийн асуулт хариултын тэмцээн явуулж, 43 иргэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, 473 иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийг хүргэн, 450 ширхэг гарын авлага, материал тараасан.

Гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг бууруулах, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль, тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор Цагдаагийн газрын хэлтэс, тасгууд хамтран 6 удаа нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион явуулсан.

Энэ хугацаанд “Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл-2018”, “Ургац”, “Оюутан тээвэр 2”, “Хичээлийн шинэ жил”, “Мөнгө угаах”, “Unfriend хөдөлгөөн” нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд салбар төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан.

Тухайлбал: Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулагдсан “Орон нутгийн зам, хөдөлгөөний соёл 2018”, “Оюутан тээвэр 2” нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд Ховд-Улаанбаатар, Ховд-Булган сум, Ховд-Говь-Алтай аймгийн чиглэлийн А-0302, А0304 кодтой олон улсын болон улсын чанартай замд аймгийн авто тээврийн газрын мэргэжилтэн 1, замын цагдаагийн 2 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг аймгийн төвөөс 78 км зайд байрлах цагдаагийн байнгын постод болон хөдөлгөөнт эргүүлээр тогтмол ажиллуулж, аймгийн газар тариалангийн бүс нутаг болох Буянт, Мянгад сумдын чиглэлийн авто замд хяналт шалгалт хийж ажилласан.

Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх “Хичээлийн шинэ жил”, “Unfriend хөдөлгөөн” нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд аймгийн Жаргалант, Алтай, Булган зэрэг 17 суманд үйл ажиллагаа явуулж буй төрийн 116 аж ахуйн нэгж, байгууллагад уг арга хэмжээг байгууллага дээрээ зохион байгуулах талаар албан бичгийг хүргүүлэн, 2000 ширхэг сургалтын материал, гарын авлага тараан, мэргэжил, арга зүйгээр ханган, хамтран ажиллав.

“Камержуулалт” нэгдсэн арга хэмжээг энэ оны 08 дугаар сарын 07-оос 09 дүгээр сарын 07-ны хооронд зохион байгуулж, үйл ажиллагаа явуулж буй 156 аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэл хүргүүлэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялангуяа хулгайн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1280 хүнд сургалт, яриа таниулга хийсэн.

Арга хэмжээний хүрээнд нийт 87 аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн камержуулсан.

Б. Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, хүний нөөцийн чиглэлээр:

Тус цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлыг 6 удаа хуралдуулж, байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр 22, хүний нөөцийн чиглэлээр 11 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Төрийн албанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, шударга байдал, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн алба хаагчдыг ажлын байр /албан тушаал/-нд томилох, дэвшүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд ЦЕГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/212 дугаар тушаалаар тус Цагдаагийн газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтний орон тоог шуурхай удирдлагын тасгийн даргын орон тоонд шилжүүлсэнтэй холбогдуулан тус тасгийн даргаар мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад Д.Бямбасүрэнг томилуулахаар холбогдох материалыг хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

ЦЕГ-ын даргын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/212 дугаар тушаалаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад Шуурхай удирдлагын тасаг байгуулах, албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг баталсантай холбогдуулан тус тасгийн алба хаагчдын ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн даргаас ирүүлсэн ажлын чиглэл, зааварчилгааны хүрээнд цахим сан болон хувийн хэргийн баяжилт хөдөлгөөнийг холбогдох хууль, журамд заасны дагуу хөтлөн тулгалт хийж, хүний нөөцийн цахим санд 19 алба хаагчдын дутуу, алдаатай мэдээллийг засаж, баяжуулсан.

Алба хаагчдын талаарх мэдээллийг цахим санд бүрэн оруулж, ахлагч бүрэлдэхүүний хувийн хэрэгт сарын ажлын үр дүнгээр цалин нэмсэн болон хассан, сахилгын шийтгэл оногдуулсан, ажлын байр өөрчилсөн, удаан жилийн нэмэгдэл олгосон, шагнал урамшилд тодорхойлогдсон, шагнагдсан, сургууль, дамжаа төгссөн, нөөцөд авагдсан зэрэг мэдээллийн баяжилтыг хийж хэвшсэн.

Цагдаагийн байгууллагад анх орж ажиллахаар хүсэлтээ гаргасан иргэдийг судлах, шалгаруулах, томилох, албан тушаалд дэвшүүлэхдээ Цагдаагийн Ерөнхий Газрын даргын тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх” журмыг мөрдөн шинээр ахлагчийн бүрэлдэхүүнд 3 алба хаагчийг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан “Албан тушаал дэвшүүлэх” журам /код 909/-ын 909.7-д заасны дагуу 1 алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн, 3 алба хаагчийн ажлын байрыг өөрчлөх саналыг тус тус холбогдох газар хүргэн шийдвэрлүүлсэн.

Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг тухай бүр бүрэлдэхүүнд танилцуулж хэвшсэн.

В.Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Тус цагдаагийн газрын хэлтэс, тасгийн дарга нар 7 хоногоор ажлаа төлөвлөж, хийсэн ажлын тайланг тасгууд хуваарийн дагуу бүрэлдэхүүнд танилцуулж, удирдлагаас өгсөн ажлын чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг тооцон цаашид хийх ажлаа төлөвлөж хэвшсэн.

Цагдаагийн газрын даргаас хэлтэс, тасгийн дарга, алба хаагч нарт ажил сайжруулах үүрэг, зааварчлага 5-г бичиж, биелэлт үр дүнг тооцсон.

Өгсөн үүргийг хэрэгжүүлээгүй, биелүүлээгүй алба хаагч байхгүй байна.

Алба хаагчдын ажлыг сар бүр дүгнэж, цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн цалинг үр дүнгээр олгож хэвшсэн.

Энэ хугацаанд сарын ажлын үр дүнгээр 4 алба хаагчийн цалинг 5 хувь, 56 алба хаагчийн цалинг 10 хувь, 1 алба хаагчийн цалинг 15 хувь, 4 алба хаагчийн цалинг 20 хувиар тус тус нэмж, ажлын үр дүн хангалтгүй, өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй 8 алба хаагчийн цалинг 10 хувь, 1 алба хаагчийн цалинг 15 хувь, 4 алба хаагчийн цалинг 20 хувь тус тус хасч олгосон байна.

Сумдын хэсгийн төлөөлөгч нарын ар гэрийнхэнтэй 1 удаа уулзалт зохион байгуулж, 4 алба хаагчийн ар гэрийн хүнийг ажлын байраар хангах асуудлыг тухайн сумын удирдлагуудтай ярилцаж тохирсон.

Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, ахлахаас хэсгийн төлөөлөгч нарын амьдрал ахуйтай нь танилцан санал бодлыг сонсож хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн явуулж байна.

Алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор ХААН, Голомт банкны Ховд аймаг дахь салбартай хамтран ажиллах тусгай нөхцөлтэй гэрээ байгуулан, 12 алба хаагчдад орон сууцны, 86 алба хаагчдад цалингийн зээлийн тодорхойлолт гарган өгч шийдвэрлүүлсэн.

Цагдаагийн газраас өөрийн хүсэлтээр цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах хүсэлт гаргасан 6 алба хаагчийн материалыг бүрдүүлэн Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлсэн.

Цэргийн байнгын тэтгэвэрт гарсан алба хаагчдыг Цагдаагийн газрын удирдлага болон холбогдох тасгийн хамт олон хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, залуу алба хаагчдад сургамж, зөвлөгөө өгүүлэх, ажлын арга туршлагаасаа харилцан ярилцах арга хэмжээг зохион байгуулж, дурсгалын зүйл гардуулан өгч хэвшсэн.

Цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 2 алба хаагчийг оролцуулан “Би албаараа бахархдаг” уулзалтыг зохион байгуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Г.Байгууллагын удирдлагад хандаж ирүүлсэн өргөдөл,
гомдол шийдвэрлэлтийн талаар:

Энэ оны эхний 9 сарын байдлаар Цагдаагийн газрын удирдлагад иргэд, аж ахуйн нэгж байгууллага болон алба хаагчдаас 140 өргөдөл гомдол ирүүлснийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Эдгээрийн 41 нь ажилд орох, 3 нь дахин ажилд орох, 29 нь ажил өөрчлөх, шилжин ажиллах, 25 нь захиргааны чөлөө хүссэн, 13 нь орон сууц, тэтгэвэр, тэтгэмж хүссэн, бусад 29 байна.

Д.Судалгаа, дүн шинжилгээ хийсэн
ажлын талаар:

Ховд аймгийн хэмжээнд 2018 оны 3 дугаар улиралд 101 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19 хэргээр буюу 23,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бүртгэгдэх үедээ сэжигтэнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 31 хэрэг бүртгэгдсэнээс 14 хэргийн нөхөн илрүүлж гэмт хэргийн илрүүлэлт 45,1 хувьтай байгаа нь өмнө оны мөн үеэс 2,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хулгайлах гэмт хэрэг 21 бүртгэгдсэн нь 6 хэргээр буюу 22,2 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь 6 хэргээр буюу 46,1 хувиар тус тус буурсан байна.

Хүчиндэх гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 100 хувиар, залилах гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь 9 хэргээр буюу 9 дахин, мал хулгайлах гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь 6 хэргээр буюу 6 дахин, бусад гэмт хэрэг 6 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 50 хувиар тус тус өсчээ.

Бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 2, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 30, дээрэмдэх гэмт хэрэг 3, хөрөнгө завших гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 2017 оны мөн үеийн түвшинд байна.

2017 оны мөн үед бүртгэгдээгүй хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 8, хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох 2 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Ховд аймгийн хэмжээнд 3 улиралд 634 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 199 буюу 45,7 хувиар өсч, зөрчил гаргасан 638 иргэнийг 100,735,000 мянган төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 148 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодсон эрхийг хасах арга хэмжээ авч шийдвэрлэсэн байна.

Албадан саатуулах байранд 275 хүн эрүүлжүүлэгдсэнээс 8 буюу 2,9 хувийг эмэгтэй хүн эзлэж байна.

Е.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйг

сурталчлан таниулах чиглэлээр:

Прокурорын газартай хамтран тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гарган, авлига, гэр бүлийн хүчирхийлэл, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, хар тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус 62 байгууллагын 1850 гаруй иргэнд 17 удаагийн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Мөн 1500 ширхэг гарын авлага, материал тарааж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Хууль эрх зүйн хэлтэс, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран давхардсан тоогоор төрийн 41, төрийн бус 46 байгууллагын 4350 ажилтан, алба хаагчдад “Зөрчлийн тухай хууль”, “Эрүүгийн хууль” болон “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд таны оролцоо”, “Хүүхдээ хүмүүжүүлэх эерэг арга” зэрэг сэдвүүдээр 87 удаа сургалт зохион явуулсан.

Хоёр: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

А. Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:

Эрүүгийн цагдаагийн тасаг нь 2018 оны 03 дүгээр улиралд Эрүүгийн цагдаагийн албанаас 141 албан бичиг хүлээн авч, 93 албан бичигт заасан үүрэг, даалгавар ажлын чиглэл, саналуудыг гаргаж холбогдох алба, газар хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд 74 холбогдогчтой 46,000,000 төгрөгний хохиролтой 24 хэргийг илрүүлж, мөрдөн байцаах тасагт шилжүүлэн, мөн 5 хэргийг илрүүлж шүүхэд шилжүүлсэн, 3 хэргийг харьяаллын дагуу бусад газар хэлтэс рүү хүргүүлсэн, 11 хэргийг хаасан, одоо ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 97 хэрэгт ажиллагаа хийж байна.

Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн алба бусад газар хэлтсээс ирүүлсэн удирдамжийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эзэнгүй хэргийг илрүүлэх чиглэлээр "Соёлын өв", "Маршрут", "Гивлүүр", "Бүртгэл хяналт", "Илрүүлэлт оргодол шийдвэрлэлт-2018" "Мөнгө угаах" "Гав" зэрэг арга хэмжээг тус тус зохион байгуулав.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах ASAP санд зарлагдсан хүн, оргодол, цогцосыг эрэн сурвалжилж олж тогтоох чиглэлээр ажиллах төлөвлөгөөний биелэлтийг тооцон ажиллаж байгаа ба эрэн сурвалжлагдаж байсан оршин суугаа газраасаа гарч, сураггүй алга болсон 7 иргэнийг олж тогтоон ар гэр асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн.

Энэ хугацаанд 17 оргодол, 209 эд зүйлийг эрэн сурвалжлан олж тогтоон, эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Мөн гэмт хэрэг үйлдэн оргон зайлсан этгээдүүдийг дайчлан баривчлах зорилгоор "Гав" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж арга хэмжээний хүрээнд 6 этгээдийг Улаанбаатар хотоос дайчлан баривчилж хэргийг шийдвэрлэсэн.

ЦЕГ-ын Интерполын үндэсний товчоонд эрэн сурвалжлагдаж байгаа О.Цагаанхишигийг олж тогтоох чиглэлээр мэдээлэл солилцон ажиллаж байна.

Б. Мөрдөн байцаах албаны чиглэлээр:

Тус тасгаас 2018 оны 03 дугаар улиралд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 40 гомдол мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 8, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 4, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 26, харьяаллын дагуу 1, ажиллагаанд 1 гомдол мэдээлэлтэй байна.

Нийт 50 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас хэрэг бүртгэлтийн хэрэг хаасан 20, яллагдагчаар татсан 11, харьяалалын дагуу шилжүүлсэн 2, ажиллагаанд 17 хэрэг байна.

Мөрдөн байцаалтын нийт 41 хэрэгт ажиллагаа явуулснаас шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлсэн 28, нэгтгэсэн 4, үлдэгдэл 9 хэрэг байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6-д заасныг хэрэгжүүлэн, иргэн аж ахуйн нэгж байгууллагад 23 мөрдөгчийн мэдэгдлийг хүргүүлэн, хариуг тооцон ажилласан.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан 24.500.000 төгрөгний хохиролоос мөрдөн байцаалтын шатанд 16.000.000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

В.Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хуулийн этгээдээс ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 118 гомдол, мэдээлэл хүлээн авч, 65 гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, 8 гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 45 гомдол, мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай хүргүүлж шийдвэрлэсэн.

Хэрэг бүртгэлтийн 8 хэрэг нээн мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 3 хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай хүргүүлж, 4 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж шийдвэрлэснээс хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай хүргүүлсэн 1 хэрэг нэмэлт ажиллагаа хийлгүүлэх саналтай буцсан, ажиллагаанд хэрэг бүртгэлтийн 2 хэрэг байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар мөрдөн байцаалтын 72 хэрэг шалгаж, 68 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 2 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай шийдвэрлэсэн, 2 хэрэг одоо ажиллагаанд шалгагдаж байна.

Прокуророос 1 хэрэг нэмэлт ажиллагаанд буцсан.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид учирсан 41,005,9 төгрөгийн хохирлоос 33,730,0 төгрөг буюу 82,2 хувийг нөхөн төлүүлж, гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор 71,544,0 төгрөгийн эд хөрөнгө битүүмжлэн хамгаалсан.

Тасгийн алба хаагч нарын өдөр тутам хийсэн ажлын тэмдэглэл, шалгаж буй гомдол, мэдээлэл, зөрчлийн хэрэгтэй танилцаж, мэргэжлийн удирдлагаар ханган, үүрэг, ажлын чиглэл өгч биелэлтийг нь тухай бүр тооцон ажиллаж байна.

Г. Замын цагдаагийн албаны чиглэлээр:

Тус тасаг нь 2018 оны 3 дугаар улиралд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор гудамж замын хяналтаар 25 алба хаагч үүрэг гүйцэтгэж, 2782 зөрчил илрүүлсэн.

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1, 7.5 дахь заалтыг зөрчиж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэсэгсэл жолоодсон 163 жолоочийг илрүүлэн гарч болзошгүй зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлж 133 жолоочийн эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, шийтгэлийн хуудсаар 53 сая 200 мянган төгрөгийн торгууль оногдуулж, эрхийн үнэмлэхгүй буюу эрх хасагдсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 31 иргэнийг сум дундын шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчилж, эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон 60 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж шийтгэлийн хуудсаар 12 сая төгрөгөөр торгож ажилласан.

Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар 2558 жолоочид бэлэн бус торгуулийн шалгах багажаар 126 сая 621 мянган төгрөгийн торгууль оногдуулсан.

Тээврийн хэрэгсэл түр саатуулах байранд 233 тээврийн хэрэгслийг түр саатуулсан.

Цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны 102 дугаарын утсанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн зам тээврийн ослын 28 гомдол, мэдээллийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код-202-д заасны дагуу хүлээн авснаас 2 гомдол мэдээллийг харъяаллын дагуу мөрдөн байцаах тсагт шилжүүлж, 26 гомдол мэдээлэлд зөрчлийн хэрэг нээн шалгаж шийдвэрлэсэн.

“Орон нутгийн зам хөдөлгөөний соёл-2018” аян, “Оюутан тээвэр-2”, “Ургац” нэгдсэн арга хэмжээнийн хүрээнд Жаргалант сумаас гадагш чиглэсэн авто замууд болон Улсын чанартай А/0304 дугаартай хатуу хучилттай Алтай чиглэлийн зам, Ховд аймгаас Булган сум-Улсын хил чиглэлийн замуудын уулзварт байрлах Манхан сумын хяналтын постод 1 офицер, 1 цагдааг томилон 24 цагаар 7 хоногийн хугацаатай үүрэг гүйцэтгэж ажиллах хугацаанд хөдөлгөөнд оролцож буй иргэд, жолооч нарт 2 төрлийн 180 ширхэг санамж сэрэмжлүүлэг бэлтгэн тараасан.

Эрхийн үнэмлэхгүй буюу эрх хасагдсан үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож, баривчлах шийтгэл хүлээсэн 36, төрийн байгууллагын 280 хүнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоноос үүсэх хор уршиг, 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөх замын хөдөлгөөний шинэчлэн батлагдсан дүрмийн талаар 13 удаа 18 цагийн сургалт явуулсан.

Ховд-Булган-Улсын хил чиглэлийн хатуу хучилттай авто зам дагуу нутагладаг Мөст, Цэцэг, Алтай, Үенч сумдын 40 айл өрхийн 120 иргэнд Ховд-Азза, Мэргэжлийн хяналтын газрын авто замын улсын байцаагчтай хамтран 200 гаруй малчдад яриа таниулга хийсэн.

Цагдаагийн Ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас Дарви, Манхан, Мянгад сумдад баригдах замын хяналтын постын цахим тендерийг зарлан, шалгаруулж, уг тендерт “Баруун жонон” ХХК шалгарч, барилга угсралтын ажил 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн явагдсан ба аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдөр улсын комисс хүлээн авч, үйл ажиллагааг эхлүүлэн, замын хөдөлгөөний хяналтын постуудад хурд сааруулагч хийх, түмбэ байрлуулах ажлыг зохион байгуулав.

Замын цагдаагийн албаны Техник замын хяналтын хэлтсээс ирүүлсэн календарчилсан төлөвлөгөөний дагуу “Эвдрэл гэмтэл-Техникийн зөрчил”, “Гэрэлтүүлэх хэрэгсэл”, “Бүрэн бус тээврийн хэрэгсэл” сэдэвт хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, 655 зөрчил илрүүлэн, 13 сая 100 мянган төгрөгийн торгууль оногдуулсан.

Д. Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:

Эргүүлийн чиглэлийг оновчтой зохион байгуулах зорилгоор 2018 оны эхний хагас жилийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, алба хаагчдын гаргасан саналд тулгуурлан 2018 оны эргүүлийн нэгдсэн байршилтыг боловсруулж, эрүү, хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан өдөр, оройн ээлжээр явган болон автомашинтай эргүүлийг зохион байгуулсан.

Ардын Хувьсгалын 97 жилийн ойн баяр наадым хамгаалалт, Мянгад сумын төрийн тахилгат Алтан Хөхий Уулын тэнгэрийг тайх ёслолын арга хэмжээ, Урианхай Сурын улсын аварга шалгаруулах тэмцээн, УИХ-ын гишүүн С.Бямбацогт зарим сумдад иргэдтэй уулзах уулзалт, Байтагийн тулгаралт дууссаны 70 жилийн ой болон сумын сургууль, эмнэлгийн ой, цолны мялаалга наадам зэрэг 34 удаагийн олон нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтыг зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан.

Аймгийн төв Жаргалант суманд малын гоц халдварт “Боом” өвчин гарсантай холбоотой аймгийн Засаг даргын хорио цээрийн дэглэм тогтоох тухай захирамжийн дагуу 6 постонд 18 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Аймгийн шүүх, прокурорын газартай хамтран зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлын талаар 1 удаа, шүүхийн Тамгын газартай хамтран шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, учирч болзошгүй эрсдлийн талаар 1 удаа хэлэлцүүлэг, зөвлөгөөнийг зохион байгуулж, тулгамдсан асуудлын талаар харилцан ярилцаж, тодорхой шийдвэр гаргасан.

Иргэд, байгууллагаас зөрчлийн талаар 329 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 40-д зөрчлийн хэрэг нээж, 120-г хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн бөгөөд 167-г хүлээн авахаас татгалзаж, харьяаллын дагуу 2-г шилжүүлсэн.

Зөрчил гаргасан 141 хүнийг Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 13.610.000 төгрөгөөр торгож, шүүхээр 19 хүнийг 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулсан.

Тайлангийн хугацаанд Ховд аймаг дахь Сум дундын шүүхэд иргэний хэргийн 269, эрүүгийн хэргийн 150, захиргааны хэргийн 8 шүүх хурлын дэг сахиулж ажилласан.

Харуулын цагдаа нар шүүхийн байранд 24 цагаар үүрэг гүйцэтгэхдээ аймгийн төвд 1022 иргэнийг шалган бүртгэж, шүүхийн байранд нэвтрүүлэн ямар нэгэн зөрчил, дутагдалгүй ажилласан.

Энэ хугацаанд Цагдан хорих байрнаас шүүхэд 6 удаа 6 шүүгдэгчийг, шүүхээс Цагдан хорих байранд 10 удаа 15 шүүгдэгчийг хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/40, 113 дугаартай “Яллагдагчийг хуяглан, албадан ирүүлэх, эрэн сурвалжлах журам”-ын дагуу албадан ирүүлэх 9 захирамж хүлээн авч биелэлтийг хангасан.

Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс иргэний хариуцагчаар эрэн сурвалжлуулахаар даалгасан 9 хүнийг олж тогтоон, оршин суугаа хаягийг шүүхэд хүргүүлсэн.

Эрүүлжүүлэх байранд нийт 392 иргэн, баривчлах байранд 90 хүн, бүгд 482 хүн хүлээн авч, согтуурлын зэргийг тогтоон, эрүүл мэндийн үзлэг хийж, 95 хүнд хордлого тайлах, цус тогтоох, өвчин намдаах зэрэг эмнэлгийн анхны тусламж үзүүлж, 12 хүнийг Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн түргэн тусламж дуудан үзүүлж, эмчлүүлэх боломжоор ханган, зөрчил гаргасан 96 хүнийг асран хамгаалах хүнд нь тэмдэглэл үйлдэн хүлээлгэн өгсөн.

Зөрчлийн тухай хуулиар 7-30 хоногийн баривчлах шийтгэвэртэй хүргэгдэн ирсэн 90 хүнийг хүлээн авч, журмын дагуу шийтгэлийг эдлүүлсэн.

Эмч, цагдаа нар нь эрүүлжүүлэх баривчлах өрөөнд байрлагчдын аюулгүй байдалд теле камераар болон биечлэн хяналт тавьж, эрүүл мэндийг нь тогтмол үзэж, журмын дагуу тодорхой цагуудад буцалсан ус, сахартай цай өгөх, телевизор үзэх, ном, сонин унших зэргээр үйлчилж ажиллалаа.

Е. Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйг сурталчлан таниулах, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучудын хөгжлийн газар, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран ажиллаж байна.

Энэ хугацаанд хүүхэд багачуудыг гол усны үер, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 80 аж ахуй нэгж, байгууллагад албан мэдэгдэл хүргүүлж, үр дүнг тооцсон.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 1 этгээдийг хяналтад авч, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйчтэй хамтран 2 удаа уулзалт, ярилцлагыг

хийж, дахин гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхгүй байх талаар 4 удаа яриа таниулга, зөвөлгөө өгсөн.

Захиргааны хяналтад байгаа 1 хүүхдэд байнгын хяналт тавьж, сар бүр эцэг, эх, асран хамгаалагчдын хамтаар уулзан, хууль зүйн зөвөлгөө өгч ажилласан ба засарч төлөвшсөн тул хяналтыг зогсоосон.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран баруун 5 аймгийн багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн төлөөлөгч, мөрдөгч нийт 80 хүнийг хамруулсан “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт хамтын ажиллагаа”, Гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, Дэлхийн зөн ОУБ-ын Ховд ОНХХ хамтран гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг мэргэшүүлэх, чадваржуулах чиглэлээр ерөнхий боловсролын 24 сургуулийн нийгмийн ажилтнуудад “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон насанд хүрээгүй хүүхдүүдэд хэрхэн холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх, хамтран ажиллах нь” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан.

2018 оны эхний 9 дүгээр сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн шинжтэй 93 дуудлага мэдээлэл хүлээн авч, жижүүрийн бүрэлдэхүүн, хэсгийн байцаагчийг оролцуулан, гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын зэргийн түвшинг нийгмийн ажилтантай хамтран тогтоож, хохирогчид сэтгэл зүйн болон хуулийн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх, төрөл садангийн хамгаалалтад өгөх ажлыг зохион байгуулсан.

Энэ хугацаанд иргэний эрсдлийн үнэлгээг гаргаж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 61 хүнийг баривчлуулж, “Архидан согтуурахтай тэмцэх тухай”, “Зөрчлийн тухай” хууль, “Хулгай, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалтыг Гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын сэтгэл зүйчтэй хамтран явуулсан.

“Хичээлийн шинэ жил” нэгдсэн арга хэмжээний хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын 24 сургуулийн захирал, эрхлэгч нартай хамтран ажиллах гэрээг байгуулсан.

Ховд их сургууль, Политехник коллеж болон ерөнхий боловсролын 24 сургуулийн 3200 гаруй оюутан, сурагчдад “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Насанд хүрээгүй хүмүүс, өсвөр үеийнхний гэмт хэрэг, зөрчилд өртөж, холбогдож байгаа шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх нь”, “РС цахим тоглоомын хор уршиг”, “Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 28 удаа, Прокурорын газартай хамтран 4 удаа 321 эмэгтэй сурагчдад охидыг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэл хийж, 3500 ширхэг гарын авлага, материалыг тараасан.

Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтийн эрх зүйн болон мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлэх, цахим орчны зохистой хэрэглээг дэмжих, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор “UNFRIEND” аяныг явуулж, 68 аж ахуйн нэгж, байгууллагад албан бичиг хүргүүлэн, зурагт хуудас 500, гарын авлага 100 ширхэгийг иргэд, олон нийтэд тараасан.

Ё. Дотоодын цэргийн тусгай салааны үйл ажиллагааны чиглэлээр:

Тусгай салаа нь улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд хэвийн зохион байгуулан удирдаж, хамгаалалтад үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоог амралт, ачааллыг нь тэнцүүлэн долоо хоногоор хийж, батлуулан мөрдөн ажилласан.

Үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нэг бүрийг зэвсэг тусгай хэрэгсэл, гав, резинэн бороохой, ПМ маркийн гар буу болон хийн гар буу, сум хамгаалах хантааз зэргээр хангаж, улсын онц чухал объектын хамгаалалтыг тусгайлсан үүрэг, чиглэл өгөхөөс

бусад үед ердийн цагийн байдлаар зохион байгуулан ажиллаж алба хаагчдын үүрэг гүйцэтгэлт, үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, чиглэл зааварчилга өгч ажилласан.

Холбоо харилцааг суурин болон гар радио станц, дотуур холбоо АТС утас ашиглан мэдээ мэдээллийн шуурхай байдлыг бүрэн ханган, тогтоосон цагуудад холбогдох албан тушаалтанд дамжуулан ажилласан.

Энэ хугацаанд улсын онц чухал объектоор:

- Байнгын үнэмлэхээр нэвтэрсэн иргэн 620
- Гаднаас нэвтэрсэн иргэд 553
- Гадаадын иргэн 0
- Тээврийн хэрэгсэл 271
- Хяналтанд авсан хөдөлгөөн 1856, нийт 3300 хөдөлгөөн шалган нэвтрүүлж ажилласан.

Харуулын 3,4 дүгээр цэгээр нийт 20 тн ачаа, 1113 толгой бог, 145 толгой бод мал нэвтрүүлж, дамжин өнгөрүүлж, “Дөргөний усан цахилгаан станц”-ын хамгаалалтад үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг долоо хоног бүр байрлал дээр нь ээлж хүлээлцүүлэн холбогдох үүрэг чиглэлээр ханган хяналт тавьж ажилласан.

2018 оны 3 дугаар улиралд Улаанбаатар хотоос Завхан аймгийн чиглэлд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэсэн 180 тн, Баянөлгий аймгаас Ховд аймгийн Хөшөөтийн уурхайн чиглэлд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэсэн 7.4 тн ачаатай тээврийн хэрэгсэлийг хамгаалалтад авч, тус аймгийн нутгаар дамжин өнгөрүүлж аюулгүй байдлыг нь ханган, зөрчил дутагдал гаргаагүй болно.

Гурав: Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар:

А. Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ, түүний үр дүн:

Цагдаагийн байгууллагын алба хаагчдын ёс зүй болон сахилгын дүрмийг мөрдөх талаар Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргаас ирүүлсэн 5/49 дугаартай үүргийг хэрэгжүүлэх, алба хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулахад хэлтэс, тасгийн дарга нарын хяналтыг тогтмолжуулах зорилгоор 13 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Алба хаагчдын сахилга ёс зүйн байдал, ажлын үүрэг гүйцэтгэлд тухайн өдрийн ёс журмын эргүүлүүд хяналт тавин, зөрчил дутагдал гаргасан тохиололд сарын ажлын үр дүнгээр хэлэлцэн шийдвэр гаргаж хэвшсэн.

2018 оны 3 дугаар байдлаар 12 алба хаагч сахилгын зөрчил гаргасан ба Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 3, Цагдаагийн газрын даргын тушаалаар 9 алба хаагч тус тус сахилгын шийтгэл хүлээсэн.

Сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагчдаас офицер 9, ахлагч 3 байна.

Сахилгын мэдээг сар бүр Цагдаагийн ерөнхий газрын Аюулгүй байдлын хэлтэст хүргүүлсэн.

Цагдаагийн алба хаагчийн сахилга ёс зүйг зөрчсөн 2 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар цагдаагийн албанаас халагдсан.

Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан “Ёс зүйн төлбөртэй сургалт”-д 2 алба хаагч хамрагдсан ба Улаанбаатар хотод албан томилолтоор ажиллах, сургалтын нэгдсэн төв, харьяа газар, хэлтсээс зохион байгуулсан сургалтад хамрагдсан 12, албан томилолтоор ажилласан 4, түр хугацаагаар шилжүүлэн ажилласан 1, Хууль сахиулахын их сургуулийн эчнээд суралцаж буй 3 алба хаагчдад сахилга ёс зүйн зөрчил гаргахгүй, хичээл сургалтыг

таслахгүй, албан ажлыг цалгардуулахгүй, архидан согтуурахгүй байх чиглэл зааварчилгаа өгсөн.

Алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангуулах зорилгоор Цагдаагийн газрын даргын шийдвэрээр 1 удаа түргэн цугларалтыг зохион байгуулж, 2 цагийн жагсаалын бэлтгэлийг явуулсан.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 255 дугаар тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулан, Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын салбар төлөвлөгөөг гаргаж, хэлтэс, тасгуудад хүргэн, хэрэгжүүлсэн ажлын талаар холбогдох алба хаагчдаас биелэлтийг гаргуулан үр дүнг тооцсон.

Алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр хэлтэс, тасгийн дарга нар болон хоногийн ёс журмын эргүүлүүд хяналт тавин, сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргасан алба хаагчдын талаар тухайн өдрийн рапортад тусган, Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийн дагуу холбогдох алба хаагч материалжуулан, албаны шалгалт явуулж, даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцэж шийдвэр гаргаж хэвшсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, Засгийн газрын 2018 оны “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын хэрэгжилт, зохион байгуулсан ажил, арга хэмжээний явц, үр дүн, Ерөнхий сайд, Шадар сайд нараас ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах чиглэлээр төрийн бүх шатны байгууллагад өгсөн үүрэг, чиглэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгах, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор салбар төлөвлөгөөний хүрээнд алба хаагчдын өрөө тасалгаанд гэнэтийн үзлэг шалгалтыг 1 удаа хийхэд алба хаагчдаас ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй.

Б. Сахилга, ёс зүйн зөрчлийн мэдээ, прокурор, шүүхийн мэдэгдэл, шаардлагын талаар:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг буруу хэрэглэж процессын зөрчил, дутагдал гаргаж прокурорын шаардлага авсан тохиолдол бүрт албаны шалгалтыг явуулж, илэрсэн зөрчилд зохих журмын дагуу хариуцлага, сахилгын арга хэмжээг авч ажилласан.

2018 оны 03 дугаар улиралд эрүү, мөрдөн байцаах тасгийн 7 мөрдөгч прокурорын шаардлагад нэр дурьдагдаж албаны шалгалт явуулсанаас 3 мөрдөгчид хариуцлага тооцох үндэслэлгүй, 4 мөрдөгчид зөрчил гаргасан нь нотлогдсон тул Цагдаагийн газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Нийтлэг гарч байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг хэрхэн илрүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг аймгийн Прокурорын газартай хамтран 2 удаа зохион байгуулсан.

Прокурорын шаардлагатай холбоотой гаргасан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хуулийг хэрэгжүүлэн, ажлын хариуцлагыг сайжруулах чиглэлээр Цагдаагийн газрын даргаас эрүү, мөрдөн байцаах тасгийн мөрдөгчдөд 2 удаа үүрэг, чиглэлийг хүргүүлсэн.

В. Алба хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, эрх зүйн актыг алба хаагч нарт 7 хоног бүрийн Даваа, Баасан гарагуудад болон албаны сургалтын цагаар холбогдох алба хаагчид сургалт, мэдээлэл хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаал, бусад хэлтэс, албадын дарга нараас ирүүлсэн үүрэг, чиглэл, ажлын зааварчилгыг тухай бүрт нь алба хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн газрын 2018-2019 онд хэрэгжүүлэх албаны сургалтын төлөвлөгөөний дагуу “Цагдаагийн алба хаагчийн ёс зүй”, “Дүрэмт болон ажлын хувцас өмсөж, хэрэглэх журам”, “Улсын бүртгэлийн ерөнхий хууль”, “Иргэний улсын бүртгэлийн тухай”, “Орон нутгийн хамгаалалтын тухай”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “Хүн амын орлогын албан татварын тухай”, “Хог хаягдлын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хууль, “Гэмт хэргийн шинжтэй мэдээ, мэдээлэл бичих аргачлал”, “Сэтгэл гутрах эмгэг, түүнээс сэргийлэх нь”, “Нойргүйдэл”, “Айл гэрийн аз жаргал”, “Хүнтэй харилцах урлаг”, “Хамгаалах бүс хэрэглэхийн ач холбогдол” сэдвээр тус тус сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 721 алба хаагч хамрагдсан.

Мөн Улаанбаатар хотын “Иргэдийн хэрэглээний боловсролын төв” ТББ-ын сургагч багш нартай хамтран “Ажлын байран дахь эрүүл амьдралын зөв дадал, зуршил”, “Зөв хоололт, зохистой хэрэглээ” сэдвээр сургалт явуулж, 63 алба хаагч хамрагдан, сонирхсон асуултаа асууж харилцан ярилцав.

Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс 2018 онд зохион байгуулах календарчилсан төлөвлөгөөний дагуу мэргэшүүлэх, дадлагажуулах, чадваржуулах, удирдах ажилтны сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг сар бүр хүргүүлэн, 12 алба хаагчийг мэргэшүүлэх болон давтан, чадваржуулах сургалтад хамруулсан.

Мөн төвөөс зохион байгуулсан 2 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 16 алба хаагч, Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, НҮБ-ын Хүн амын сангаас хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” баруун бүсийн сургалтад 15 алба хаагч хамрагдсан.

Хууль сахиулахын их сургуулийн цагдаагийн сургуулийн эчнээд 3 алба хаагч суралцаж байна.

Г.Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд:

Цагдаагийн газрын 2018 онд соён гэгээрүүлэх ажлын 4 бүлэг 16 заалт бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Энэ хугацаанд алба хаагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, эв нэгдлийг сайжруулах чиглэлээр зохион явуулж буй тэмцээн уралдааны үеэр баг болгон ороцуулж байгаа нь бие биенээ сонсож дэмжих, бусаддаа итгэл үзүүлэх эерэг хандлага төлөвшүүлэхэд түлхэц болж байна.

Алба хаагчдын стресс ядаргааг тайлах, дэлхий, улс, аймаг орон нутгийн талаар сонирхолтой мэдээ мэдээлэл өгөх зорилгоор өглөө бүр алба хаагчид нэрсийн дарааллаар 5 минутын хугацаатай мэдээлэл өгч байна.

Цагдаагийн газар, алба хаагчдын бусдад үлгэр жишээ болох онцлог үйл явдал, арга хэмжээний талаар тухай бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим сайтуудаар олон нийтэд хүргэж ажилласан.

Энэ хугацаанд “Би албаараа бахархдаг” уулзалт ярилцлага, “Түүхт ойнүүдыг тохиолдуулан цагдаагийн алба хаагч бүл нэмлээ”, “Цол шагнагдсан, шинээр томилогдсон алба хаагчдад хүндэтгэл үзүүлэв”, “Бид мартаггүй” зэрэг нэвтрүүлгийг аймгийн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран бэлтгэж олон нийтэд хүргэсэн.

Алба хаагчдын дунд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор Цагдаагийн газрын дарга хэлтэс, тасгуудын үйл ажиллагаатай танилцан, алба хаагчдын санал хүсэлтийг сонсон, амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой 3 алба хаагчдын хүүхдүүдэд тусламж үзүүлэн, шинээр 1 дүгээр ангид элсэн суралцаж байгаа 6 алба хаагчийн хүүхдэд хичээлийн хэрэгсэл олгосон.

Мөн алба хаагчдын ахуй амьдралтай танилцах зорилгоор “Гэр, орон сууц, ахуй нөхцөлийн судалгаа”-г авч, тусламж дэмжлэгийг үе шаттайгаар үзүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэ хугацаанд шинээр гэр бүл болсон, хүүхэд мэндэлсэн, уй гашуу тохиолдсон зэрэг 6 алба хаагчдад хамт олны зүгээс дэмжлэг тусламж үзүүлж, ар гэрийн амьдрал ахуйтай нь холбогдуулан 1 алба хаагчийг аймгийн төвд шилжүүлэн томилсон.

Түүнчлэн алба хаагчдаас ирүүлсэн саналын дагуу тэдний хүүхдүүдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх, чөлөөт цагийг нь үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор “Би дуулж, бүжиглэж чадна” урлагийн, “Би гэр бүлдээ жаргалтай” “Миний хамгийн эрхэм зүйл” сэдэвт зохион бичлэгийн уралдааныг тус тус зохион байгуулж, оролцсон хүүхэд багачуудыг шагнаж, урамшуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Цагдаагийн газрын алба хаагчид болон тэдний гэр бүлийнхэнд зориулсан “Номын сан”-г өргөтгөн хэлтэс, тасаг бүр шинээр хэвлэгдэн гарсан орчин үеийн уран зохиолын ном, товхимолыг цуглуулах ажлыг эхлүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж буй “Байгууллагын соёлыг дээшлүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Цагдаагийн газраас хэрэгжүүлэх салбар төлөвлөгөө гарган, “Байгууллагын соёлыг төлөвшүүлэх” аяныг зарласан.

Аяны хүрээнд “Цагдаагийн байгууллагын бэлэгдэл, бахархал”, “Цагдаагийн газар үүсэн байгуулагдсан түүх”, “Хамт олны бүтээн байгуулсан амжилт” сэдвээр мэдээлэл бэлтгэн алба хаагчдад хүргэв.

Илтгэх урлагийг дээшлүүлэх зорилгоор “Хэрвээ би Цагдаагийн газрын дарга байсан бол” сэдэвт илтгэлийн уралдааныг зарласан ба дүгнэх хугацаа болоогүй байна.

Аймаг, орон нутгаас зохион байгуулсан спорт, урлагийн уралдаан тэмцээнд алба хаагчдыг тогтмол оролцуулах бодлого барьж, ажил үүрэг гүйцэтгэлийг нь зохицуулан, тэмцээний бэлтгэл хийх нөхцөл боломжоор хангасны үр дүнд Тулгар төрийн 2227, Их Монгол Улс байгуулагдсаны 812, Ардын хувьсгалын 97 жилийн ойн их баяр наадмын шагайн харваанд Албадан саатуулах, баривчлах байрны эмч, цагдаагийн ахмад Ц.Пүрэвхүү амжилттай оролцон “Аймгийн дэд мэргэн” цолны болзол хангасан.

Бөхийн барилдаанд 4 алба хаагч оролцон, 1 алба хаагч 4 даваа давсан амжилт гаргасан.

Мөн Хүч спорт хорооноос зохион байгуулсан хөл бөмбөгийн тэмцээнд 13 алба хаагч оролцсон.

Монгол орны баруун хязгаар Ховд аймгийн Булган сумын Байтаг богдын тулгаралтын 70 жилийн ойг тохиолдуулан Ховд аймгийн Залуучуудын холбоо, “Монгол-Алтай” дугуйн холбооноос зохион байгуулж байгаа “Мөнхийн залуу нас - Эх орончдын замаар 100” сэдэвт 5 хоногийн 1000 гаруй км дугуйн аялалд 2 алба хаагч, Цагдаагийн газрын үйл ажиллагааг сурталчлан, баатарлаг ахмад үе, тэдний халуун амь бүлээн цусаа урсгасан түүхт газруудтай танилцаж, алба хаагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх, тэднээр бахархах, эерэг бодол, эв нэгдэл бүхий уур амьсгалыг бүрдүүлэн, бусдаас суралцан, түүх соёлыг танилцуулах зорилготойгоор оролцсон.

“Монгол Алтай” дугуйн холбооноос зохион байгуулсан аялалд 14 алба хаагч оролцсон ба Цагдаагийн газрын төв байрнаас Ховд аймаг руу орох төв хаалга хүртэл

3.5 км, Буянт голоос Цэвэрлэх байгууламж хүртэлх 2.5 км замд 2 удаа явган аялж, замын орчим хогийг цэвэрлэн олон ястаны өлгий болсон Ховд хотоо өнгө үзэмжтэй, цэвэр, цэмцгэр байлгахын төлөө нийт иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудыг нэгдэхийг уриалсан арга хэмжээг зохион байгуулсан.

Алба хаагчдын гэр бүлийнхний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, ур ухаан, шилдэг загвар гарган бүтээсэн бүтээлийг олон нийтэд сурталчлах, түгээх зорилгоор “Миний сонирхол, миний бүтээл” сэдэвт арга хэмжээний удирдамж гарган хэлтэс, тасгуудад хүргүүлсэн ба шилдэг бүтээлийг шалгаруулан шагнаж урамшуулах, иргэд олон нийтэд сурталчлан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах үйл ажиллагааг аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж тохиролцсон.

Дөрөв. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар:

Энэ оны 3 дугаар улирлын батлагдсан төсөв болон төсвийн гүйцэтгэлд Цагдаагийн газрын удирдлагын зүгээс тогтмол хяналт тавин ажилласан ба төсвийн гүйцэтгэл, орлого, зарцуулалтын талаар сар бүр Цагдаагийн газрын ахлах нягтлан бодогч алба хаагчдад мэдээллийг нээлттэйгээр хүргэж хэвшсэн.

Тус Цагдаагийн газрын санхүүтэй холбоотой мэдээлэл болох жилийн батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн санхүүжилтийн зарлагын мэдээ, улирлын гүйцэтгэл, тайлан зэргийг шилэн данс, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлж ажилласан.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1.697.671.000 төгрөг, үндсэн үйл ажиллаганы орлого 38.554.442 төгрөг нийт 1.737.200.542 төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж дараах зарцуулалтыг хийсэн. Үүнд:

- Цалингийн зардалд 1.463.896.000,
- нийгмийн даатгалын шимтгэлд 31.899.598,
- байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 47.394.399,
- хангамж, бараа материалын зардалд 113.022.090,
- томилолт, зочны зардалд 13.681.150,

бараа үйлчилгээний бусад зардалд 46.882.496 төгрөг нийт 1.716.775.433 төгрөгийг зориулалтын дагуу хэтрэлт үүсгэлгүй үр дүнтэй зарцуулж, зарцуулалтыг сар бүр тайлагнаж ажилласан.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээлбэл зохих 98 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 96, хугацаа хоцорсон 2 байсан ба нөхөж шилэн дансанд байршуулсан.

Шилэн дансны 3 дугаар улирлын тайланг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр цахимаар илгээх болно.

2018 оны эхний 3-р улирлын байдлаар ЦЕГ-ын Хангалт үйлчилгээний төвөөс алба хаагч нарын дүрэмт хувцасны хангалтаар урт болон богино ханцуйтай цагаан, цэнхэр цамц, зуны хантаазны хангалтыг хийж, жагсаалтын дагуу алба хаагч нарт олгож, баталгаажуулан хүргүүлсэн.

Тав. Алба хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр 2018 онд хийж гүйцэтгэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн газрын дотоод аюулгүй байдлыг хангах орон тооны бус ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын А/12 дугаар тушаалаар байгуулж, орон тооны бус ажлын хэсэг 2018 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний талаар 1 удаа хуралдаж, эрсдэлийг бууруулах чиглэлээр ажлын хэсгийн гишүүдэд үүрэг чиглэл өгч үр дүнг тооцож ажилласан.

Шинээр томилогдсон 9 алба хаагчид халамжлан хүмүүжүүлэгч томилж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицож, байгууллагынхаа үйл ажиллагаа, түүхэн замнал, нутаг дэвсгэр, ажлын онцлог байдлыг танилцуулан, мэдвэл зохих хууль эрх зүйн баримт бичгийг судлуулж, амьдрах арга ухаанд сурах чиглэлээр зөвлөгөө өгсөн.

ЦЕГ-ын даргын 2015 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дасан зохицох /код 944/ журам”-ын дагуу судлах эрх зүйн акт, гарын авлага материал бэлтгэн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангасан.

Мөн гэмт хэрэг, сахилга ёс зүйн зөрчилд холбогдохгүй байх, иргэдтэй зөв боловсон хуулийн хүрээнд харьцаж, тэднийг чирэгдүүлэхгүй байх, алба хаагчдаас дэвшүүлсэн шинэ санал, санаачлагыг дэмжин, өөрийн санал хүсэлтээ илэн далангүй удирдлагад танилцуулж байх талаар зөвлөгөө өгсөн.

Энэ хугацаанд тусгай удирдамжийн дагуу алба хаагчдын дунд дугуйн, орс таталт, уулын оргил булаалдах, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөгийн тэмцээн, “Түргэн хэллэг”-ийн уралдааныг зохион явуулж алба хаагчдыг шагнаж урамшуулан, тухай бүр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Цагдаагийн газрын 18 алба хаагчаас харилцаа, хандлага тодорхойлох, Дотоодын цэргийн тусгай салааны 19 алба хаагчаас эрсдэл бэлэн байдал, харилцааны ур чадварын судалгаануудыг тус тус авсан.

2018 оны 3 дугаар улиралд 13 алба хаагчдад сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгч, бүлгийн сэтгэл засал 21 алба хаагчдад, сэтгэл зүйн чөлөөт ярилцлагыг давхардсан тоогоор 62 алба хаагчдад үзүүлсэн.

Мөн хуваарийн дагуу алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэг, хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, бие бялдрын бэлтгэлжилтийг хангах чиглэлээр 3 км гүйлтийг зохион байгуулан, 2 төрлийн тэмцээн явуулж, алба хаагчдыг шагнаж урамшуулан, бие бялдрын дасгал, гимнастикийг өглөөний ярианы дараа 8 удаа зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/199 дүгээр тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу замын хөдөлгөөний зохицуулагч нарын хөдөлмөрийн нөхцөлөөс эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй хүчин зүйл, түүний шалтгаан нөхцөл, нөлөөллийн талаар шаардлагатай мэдээллийг цуглуулах, цаашид авах арга хэмжээг тодорхойлох зорилгоор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Цагдаагийн газрын замын хөдөлгөөний 17 зохицуулагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тандалт, дүн шинжилгээ хийсэн.

Цагдаагийн газрын хэлтэс, тасгийн дарга нараас алба хаагчдынхаа ар гэрээр орж, амьдрал ахуйтай нь танилцан, гэр бүлийнхний санал хүсэлтийг сонсох ажлыг үргэлжлүүлэн явуулж байна.

Алба хаагчдын гэр бүлийнхний чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор спортын тэмцээнийг 2 удаа зохион байгуулан шагнаж, урамшуулсан.

Энэ хугацаанд ар гэрийн гачигдалын улмаас захиргааны чөлөө хүссэн 16 алба хаагчдад 1-14 хоногийн хугацаатай чөлөө олгож, шинээр хүүхэдтэй болсон 5 алба хаагчдад Цагдаагийн газрын дотоод журамд тусгагдсаны дагуу 7 хоногийн чөлөө олгосон.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд санал, хүсэлт хүргэж Unitel корпорацын Ховд аймаг дахь салбарын дэмжлэгтэйгээр хэсгийн төлөөлөгчдийн кобан байрыг цагдаагийн байгууллагын дотоод сүлжээнд холбож, 1 жилийн хязгааргүй хэрэглээний “Гэр интернет”-ийг шийдвэрлүүлсэн.

Зэрэг сумын цагдаагийн хэсгийн кобаны байр нь 2007 онд ашиглалтад орсон ба дээрх хугацаанд ямар нэгэн засвар үйлчилгээ хийгдээгүй хэсгийн төлөөлөгч цагдаа нар ажил үүрэг гүйцэтгэхэд хүндрэлтэй байсныг холбогдох газарт уламжлан 4,700,000 төгрөгөөр засварлан ашиглалтад оруулсан.

Цагдаагийн газрын дадлага, сургалтын төвийг барих талаар аймаг орон нутгийн удирдлагад танилцуулан, 1 га газрыг шийдвэрлүүлэн, төсөв тооцоог гарган орон нутгийн 2019-2020 оны төсөвт тусгахаар шийдвэрлэсэн.

Олон нийтийн цагдаагаар тогтвор суурьшилтай ажиллаж байгаа 11 ажилтаны хөдөлмөр аюулгүй байдлын тусгай хувцасыг ирүүлсэн загварын дагуу захилгыг Мөрдөс үйлдвэрт хүргүүлсэн.

Дүгнэлт:

Энэ оны 3 дугаар улиралд хүчиндэх гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 1 хэргээр буюу 100 хувиар, залилах гэмт хэрэг 10 бүртгэгдсэн нь 9 хэргээр буюу 9 дахин, мал хулгайлах гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь 6 хэргээр буюу 6 дахин, бусад гэмт хэрэг 6 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 50 хувиар тус тус өсчээ.

2017 оны мөн үед бүртгэгдээгүй хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 8, хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох гэмт хэрэг 2 бүртгэгдсэн байна.

Ховд аймгийн хэмжээнд 3 улиралд 634 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 199 буюу 45,7 хувиар өссөн байна.

Иймд гарсан гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, олон нийтийн дэмжлэгийг авч, оновчтой хэлбэрээр зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байгаад анхаарч ажиллана.

Цаашид анхаарах асуудал, хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1. Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, илрүүлэх чиглэлээр бусад аймаг, нийслэлд зохион байгуулж, үр дүнгээ өгч буй тодорхой ажил, арга хэмжээний туршлагаас судлан, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, үр дүнг тооцож хэвших.

2. Алба хаагчдын бие бялдар, эрүүл мэндийн байдлыг дээшлүүлэх, мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн ерөнхий газар, бусад газар, хэлтэс, аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтад алба хаагч бүрийг хамруулах.

3. Баруун бүсийн сургалтын нэгдсэн төв байгуулах ажлыг эхлүүлэх.

4. Аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тавих хяналт шалгалтыг дээшлүүлж, гудамж, зам талбай, олон улсын болон улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу стандартын шаардлага хангасан тэмдэг, тэмдэглэл, гэрэлтүүлэг, теле хяналтын камерын тоог нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудад санал, зөвлөмж хүргүүлж шийдвэрлүүлэх болно.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.БАТЗАЯА